



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 157

Номгон

Монгол Улсын “Гавъяат” цол,
Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулах
хүмүүсийн тодорхойлолт өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“ГАВЪЯАТ ЭДИЙН ЗАСАГЧ” ЦОЛ ТЭМДЭГЭЭР

1. Чулууны Амгалан-Баянхонгор сумын ахмад настан

“АЛТАН ГАДАС ОДОН”-ГООР

1. Цэвэлхүүгийн Эрдэнэ-Очир-Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга

2. Хившээгийн Цэцгээ-Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Нийгмийн халамжийн мэргэжилтэн

3. Сүхцэрэнгийн Оюун-Баянхонгор сумын 1 дүгээр багийн иргэн

“ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-ИАР

1. Гончигжавын Энхтүвшин-Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг дахь салбарын тэргүүн

2. Бямбажавын Одмаа-Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн Нийгмийн ажилтан

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



0117137